


**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим
хаяг: orgil.ikhuul@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.БЯМБАЖАВ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/226
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Жаргалант сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Жаргалант Хүүхдийн цэцэрлэг, 2 дугаар Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 51 иргэнтэй холбоотой 117.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Жаргалант сумын Засаг дарга нь 2022 онд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 11 зорилт, 32 арга хэмжээний биелэлт 88.7 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг

буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	952,975.5	613,837.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	265,968.9	377,484.5
33	АВЛАГА	137,212.6	110,035.8
35	БАРАА МАТЕРИАЛ	536,930.0	114,607.9
36	НӨӨЦИЙН БАРАА	12,864.0	11,709.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,457,455.9	3,539,812.9
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	115,553.2	190,576.5
37300	Урт хугацаат зээл	115,553.2	190,576.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,341,902.6	3,349,236.4
39200	Биет хөрөнгө	12,110,459.7	3,219,698.7
39300	Биет бус хөрөнгө	231,443.0	129,537.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,410,431.4	4,153,650.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	161,713.1	17,758.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	161,713.1	17,758.9
41300	Өглөг	161,713.1	1,785.6
41400	Урьдчилж орсон орлого	0.0	15,973.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,248,718.3	4,135,891.6
51	Засгийн газрын хувь оролцоо	13,248,718.3	4,135,891.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,790,940.0	3,011,043.6
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,790,940.0	3,011,043.6
51101	Өмч /төрийн/ /ЛӨҮГ/	80,450.2	142,330.2
51200	Хуримтлагдсан үр дүн	6,638,857.2	789,379.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,738,470.8	193,138.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,410,431.4	4,153,650.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,982,802.6	1,999,971.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	489,548.4	667,081.2
110	Орлогын албан татвар	80,436.4	301,860.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	80,436.4	323,327.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-21,467.7
113	Хөрөнгийн албан татвар	23,874.6	66,069.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	385,237.4	299,152.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,409,444.5	81,576.6
120	Нийтлэг татварын бус орлого	2,409,444.5	81,576.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,083,809.7	1,251,313.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,935,934.1	1,870,778.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,935,934.1	1,870,778.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,646,839.7	1,822,768.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,291,151.3	407,109.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	302,766.6	50,264.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	472,091.1	532,206.3
2104	Хангамж, бараа материалын зардал	179,461.4	65,022.6
2105	Нормативт зардал	430,496.1	725.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,355.7	197,205.4
2107	Томилолт, зочны зардал	6,324.6	2,751.0

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,528.6	152,024.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	743,664.5	415,460.2
212	ТАТААС	103,478.9	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,615.5	48,010.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,046,868.5	129,192.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,600.3	9,401,948.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,030,268.2	-9,272,756.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,687,775.4	2,042,259.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	489,548.4	667,081.2
110	Орлогын албан татвар	80,436.4	301,860.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	80,436.4	323,327.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-21,467.7
113	Хөрөнгийн албан татвар	23,874.6	66,069.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	385,237.4	299,152.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,577.0	21,583.2
1181	Газрын төлбөр	1,481.0	48,661.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	359,179.4	228,907.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	171,094.7	123,865.4
120	Нийтлэг татварын бус орлого	171,094.7	123,865.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,027,132.3	1,251,313.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,137,582.6	1,592,282.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,137,582.6	1,592,282.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,848,348.5	1,322,297.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,322,407.4	451,103.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,836.9	61,754.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	425,697.3	531,380.5
2104	Хангамж, бараа материалын зардал	186,305.3	77,122.5
2105	Нормативт зардал	171,241.7	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,298.9	52,795.4
2107	Томилолт, зочны зардал	6,324.6	2,751.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,665.5	84,896.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,571.0	60,494.1
212	ТАТААС	103,478.9	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	185,755.2	269,984.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	550,192.9	449,977.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	603,110.8	178,461.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	603,110.8	178,461.7
2200	Дотоод эх үүсвэрээр	603,110.8	178,461.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-603,110.8	-178,461.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-160,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	160,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-52,918.0	111,515.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	318,886.9	265,968.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265,968.9	377,484.5

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,218,450.1	0.0	11,218,450.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,051.2	0.0	3,051.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,221,501.3	0.0	11,221,501.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,051.2	0.0	-3,051.2
9	Тайлант үеийн үр дүн	2,030,268.2	0.0	2,030,268.2
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,248,718.3	0.0	13,248,718.3
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,248,718.3	0.0	13,248,718.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	98,049.6	0.0	98,049.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,346,767.9	0.0	13,346,767.9
17	Өмчид гарсан өөрчилөлт	61,880.0	0.0	61,880.0
19	Тайлант үеийн үр дүн	-9,272,756.3	0.0	-9,272,756.3
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,135,891.6	0.0	4,135,891.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,920,439.1	1,810,303.3	110,135.8	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,662,739.1	1,500,893.3	161,845.8	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,344,969.9	1,231,208.5	113,761.4	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	444,274.6	412,893.4	31,381.2	92.9
210101	Үндсэн цалин	372,058.5	344,513.5	27,545.0	92.6
210102	Нэмэгдэл	60,598.5	56,764.2	3,834.3	93.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	21.0	-21.0	
210104	Урамшуулал	11,617.6	11,594.7	22.9	99.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,630.8	49,953.1	5,677.7	89.8
210201	Тэтгэврийн даатгал	37,904.2	34,405.6	3,498.6	90.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,431.4	4,014.6	416.8	90.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,545.3	3,164.5	380.8	89.3
210204	Ажилгүйдлийн даатгал	886.2	750.2	136.0	84.7
210205	Эрүүл мэндийн даатгал	8,863.7	7,618.2	1,245.5	85.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	543,081.3	530,980.5	12,100.8	97.8
210301	Гэрэл, цахилгаан	44,350.0	39,406.9	4,943.1	88.9
210302	Түлш, халаалт	486,581.3	478,620.5	7,960.8	98.4
210303	Цэвэр, бохир ус	12,150.0	12,953.2	-803.2	106.6
2104	Хангамж, бараа материалын зардал	50,869.9	50,869.9	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	4,000.0	4,000.0	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	33,469.9	34,013.9	-544.0	101.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900.0	3,356.0	544.0	86.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000.0	4,000.0	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500.0	5,500.0	0.0	100.0

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,795.4	52,795.4	0.0	100.0
210604	Урсгал засвар	52,795.4	52,795.4	0.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,901.8	2,751.0	150.8	94.8
210702	Дотоод албан томилолт	2,901.8	2,751.0	150.8	94.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,214.4	50,377.9	52,836.5	48.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,075.4	48,516.9	52,558.5	48.0
210803	Даатгалын үйлчилгээ	99.0	99.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160.0	97.5	62.5	60.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80.0	80.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800.0	800.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	1,000.0	784.5	215.5	78.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,201.7	80,587.3	11,614.4	87.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,401.7	50,787.3	11,614.4	81.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,800.0	29,800.0	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	317,769.2	269,684.8	48,084.4	84.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	269,129.2	221,044.8	48,084.4	82.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	269,129.2	221,044.8	48,084.4	82.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,640.0	48,640.0	0.0	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,700.0	14,700.0	0.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,392.0	24,392.0	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,548.0	9,548.0	0.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	160,000.0	149,410.0	10,590.0	93.4
223001	Бусад хөрөнгө	160,000.0	149,410.0	10,590.0	93.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	97,700.0	160,000.0	-62,300.0	163.8
230001	Эргэж төлөгдөх зээл	97,700.0	160,000.0	-62,300.0	163.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,920,439.1	1,761,894.4	158,544.7	91.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	202,642.7	202,642.7	0.0	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	202,642.7	202,642.7	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,468,557.0	1,495,023.5	-26,466.5	101.8
320001	Орон нутгийн төсвөөс	1,468,557.0	1,495,023.5	-26,466.5	101.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	249,239.4	64,228.2	185,011.2	25.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.0	52,146.0	37,854.0	57.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,500.0	12,082.2	-2,582.2	127.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	149,739.4	0.0	149,739.4	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	98,895.7	-98,895.7	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	50,486.8	-50,486.8	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,979.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,979.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,321.9

2104	Хангамж, бараа материалын зардал	9,678.3
210401	Бичиг хэрэг	413.0
210402	Тээвэр, шатахуун	5,288.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	85.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,892.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,485.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,485.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,158.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,158.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,657.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	300.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,357.4
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	15,357.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,979.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,979.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,546.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,433.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Жаргалант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд "Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэгдсэн уян хатан, идэвхтэй, санаачлагатай, Төрийн албаны ёс зүйг чанд сахидаг, өндөр мэргэжлийн чадавх бүхий цомхон, мэргэшсэн, чадварлаг, эцсийн үр дүн бүтээгдэхүүнд суурилсан хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж нутгийн захиргааны үр дүнтэй хэвийн үйл ажиллагааг хангаж, хөгжил дэвшилд хүрч хөгжлийн үзүүлэлтийн түвшингээр тэргүүлэн "Идэр" бүсийн тулгуур төв болно" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт, Соёлын төв болон Эрүүл мэндийн төв нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу тус тус улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын 2021 оны 04 сарын 30 өдрийн А/70 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний шатахууны зарцуулалт, өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хамгаалалт, шилэн дансны мэдээлэл зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,256.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	266.0	377.5	111.5
Авлага	137.2	110.0	(27.2)
Бараа материал	549.8	126.3	(423.5)
Үндсэн хөрөнгө	12,341.9	3,349.2	(8,992.7)
Нийт хөрөнгө	13,410.4	4,153.7	(9,256.8)
Өр төлбөр	161.7	17.8	(144.0)

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,248.7	4,135.9	(9,112.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,410.4	4,153.7	(9,256.8)

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө нэмэгдэж, бараа материал данс, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө 111.5 сая төгрөгөөр өсөж 377.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 312.5 сая төгрөг, ОНХСангийн үлдэгдэл 48.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 2.4 сая төгрөг, Эрчимт идэр СДОАНгийн дансны үлдэгдэл 14.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Авлага 27.2 сая төгрөгөөр буурч, 110.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 106.2 сая төгрөг, Эрчимт идэр СДОАНгийн авлагын үлдэгдэл 0.09 сая төгрөг, ЗДТГын үлдэгдэл 3.7 сая төгрөг үлдэгдэлтэй байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл 423.5 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн 229.2 сая төгрөг, Соёлын төвийн 3.5 сая төгрөг Эрүүл мэндийн төвийн 101.4 сая төгрөг, 2 Хүүхдийн цэцэрлэгийн 96.2 сая төгрөгийн материал шилжүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,256.8 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Соёлын төвийн 3,265.5 сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 2,632.6 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 561.9 сая төгрөг, Хүүхдийн 1,2-дугаар цэцэрлэгийн 2,513.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.
5. Өр төлбөр данс нь 144.0 сая төгрөгөөр буурч, 17.7 сая төгрөгний өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн хөгжлийн сан 1.7 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 0.4 сая төгрөгийн урьдчилж төлсөн зээлийн хүүгийн орлого, Эрчимт идэр СДОАНги 15.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Соёлын төвийн халаалтын өр 156.2 сая төгрөгийг улсын төсвийн тайланд шилжүүлэн тайлагнасан байна.
6. Орон нутгийн өмч 9,112.8 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

1. Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 2,000.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,982.8 сая төгрөгөөр буюу 71.4 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	489.5	667.1	177.5	36.3
Татварын бус орлого	2,409.4	81.6	(2,327.9)	(96.6)
Тусламж санхүүжилтийн орлого	4,083.8	1,251.3	(2,832.5)	(69.4)
Нийт дүн	6,982.8	2,000.0	-4,982.8	(71.4)

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсөвт шилжиж улсын төсвөөс авах санхүүжилт хасагдсанаас шалтгаалсан байна. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,752.0 сая төгрөгийн орлогын давхардсан 17 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,703.5 сая төгрөгийн орлогын давхардсан 15 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 1,870.8 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 3,065.1 сая төгрөгөөр буюу 62.0 хувиар буурсан байна.

2. Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,935.9	1,870.8	-3,065.1	62
Үйл ажиллагааны бус зардал	16.6	9,401.9	9,385.3	565.3
Нийт дүн	4,952.5	11,272.7	6,320.2	127.6

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үйл ажиллагааны нийт зардлын дүн буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжиж орон нутгаас байр ашиглалтын зардлыг санхүүжүүлэх болсноор төсвийн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 62.0 хувь болж буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд үйл ажиллагааны бус зардал нэмэгдсэн нь "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,752.0 сая төгрөгийн орлогын давхардсан 17 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,703.5 сая төгрөгийн орлогын давхардсан 15 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна. Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагуудын төсвийг нэгтгэж хүргүүлсэн ба боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд нь аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна.

Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,960.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1,674.1 сая төгрөгийг урсгал зардалд, 186.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээл, хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны хяналтын зардалд 99.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 191.7 сая төгрөгийг ОНХСангийн нэгдсэн сангаас, 1,132.3 сая төгрөгийг санхүү дэмжлэгээс, 434.9 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 99.5 сая төгрөг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 86.8 сая төгрөгийг давсан орлогоос 15.0 сая төгрөг ОНХсангийн дансны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн 14 дугаар тогтоолоор төсөвт 80.6 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 1,879.5 сая төгрөгөөр баталсан байна. Газрын дуудлага худалдааны орлогоос 40.9 сая төгрөгийн Орон нутгийн орлогот төвлөрүүлж зарцуулсан.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Жаргалант сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоолд зааснаар Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 475.8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 676.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 142.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин түүнтэй адилтгах орлого	199.0	240.7	41.7	120.9
Үйл ажиллагааны орлого	10.0	28.9	18.9	288.7
Хөрөнгийн орлого	55.0	42.9	-12.1	78.0

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Хөрөнгө борлуулсны орлого	1.1	4.2	3.1	373.8
Шууд бус орлого	4.0	6.5	2.5	163.7
ХХОАТ-ын буцаан олголт	-37.5	-21.5	16.0	57.3
Үл хөдлөх хөрөнгийн албан тавар	12.8	11.7	-1.1	91.2
Бууны албан татвар	3.4	4.0	0.6	118.1
Малд ногдуулах албан татвар	48.0	50.4	2.4	104.9
Улсын тэмдэгтийн хураамж	7.3	14.4	7.1	197.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1.4	0.4	-1.0	28.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2.5	6.7	4.2	270.7
Газрын төлбөр	5.8	7.7	1.9	133.8
Газрын дуудлага худалдаа	41.9	40.9	-1.0	97.6
Ойн нөөц ашигласны төлбөр	111.9	226.8	114.9	202.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.9	0.5	-0.4	58.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	1.1	0.5	176.8
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.0	0.3	-1.7	16.5
Торгуулийн орлого	5.0	7.2	2.2	145.2
Түрээсийн орлого	0.5	2.5	2.0	526.3
ТӨСВИЙН ОРЛОГО	475.8	676.9	201.1	142.2

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Жаргалант сумын орон нутгийн орлого 201.1 сая төгрөгөөр давж биелэхэд үйл ажиллагааны орлого 18.8 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 3.1 сая төгрөгөөр, малын албан татвар 2.4 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 114.9 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 3.1 сая төгрөгөөр, торгуулийн орлого 2.2 сая төгрөгөөр түрээсийн орлого 2.0 сая төгрөгөөр хог хаягдлын хураамж 4.2 сая төгрөгөөр цалин түүнтэй адилтгах орлогын 41.7 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 12.1 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн орлого 1.1 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.4 сая төгрөгөөр, байгалийн ургамалын нөөц ашигласны 1.7 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 1.0 сая төгрөгөөр түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.1 сая төгрөг нийт 17.4 сая төгрөгөөр 6 нэр төрлийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 29.7 сая төгрөгөөр төлөвлөж 35.5 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 5.8 сая төгрөг буюу 119.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	8.7	0.0	-8.7
2	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар	0.0	0.04	0.04
3	Түрээсийн орлого	0.6	0.0	-0.6
4	Татварын торгууль	0.0	0.7	0.7
5	Татварын алданги	0.0	0.4	0.4
6	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	16.0	26.8	10.8
7	Зам ашигласны төлбөр	4.5	7.4	2.9
	Нийт дүн	29.7	35.5	5.8

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймагт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: ААНОАТ-ыг 8.7 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг 0.6 сая төгрөгөөр нийт 2 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 9.3 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 185.5 сая төгрөгөөр төлөвлөж 191.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 6.3 сая төгрөгөөр буюу 103.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	34.5	56.3	21.8
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	150.2	130.9	-19.3
3	Агаарын бохирдлын төлбөр	0.8	4.6	3.8
Нийт дүн		185.5	191.8	6.3

Эх сурвалж: Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогоноос Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 19.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,920.4 сая төгрөгөөр төлөвлөж, 1,761.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 91.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 99.5 сая төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 64.2 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,920.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,662.7 сая төгрөгийг урсгал зардалд, 160.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, , 97.7 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,500.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 149.4 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 160.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,810.3 сая төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой байна. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 31.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5.6 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 12.1 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 52.8 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 11.6 сая төгрөг
- Засгийн газрын урсгал шилжүүлэг 48.1 сая төгрөг
- Албан томилолтын зардал 0.15 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 10.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 24 төсөл арга хэмжээнд 269.1 сая төгрөг батлагдсанаас 23 төсөл арга хэмжээнд 221.0 сая төгрөгийг зарцуулж огт хэрэгжээгүй 1 төсөл арга хэмжээний 26.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, чанарын барьцаа мөн гүйцэтгэл дутуу ажлын санхүүжилтийг шилжих хөрөнгө оруулалтаар авсан байна.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь дээд шатны төсөв захирагчаас 12.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 43.4 сая төгрөг нийт 55.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 40.3 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 0.3 сая төгрөг зарцуулж 15.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дуаар сарын 01-ний өдрийн 1/138 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 98.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 78.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны байгууллагуудаас Хүүхдийн 1,2 дугаар цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн 5 байгууллага улсын төсөвт шилжсэнээр тайлант оны үйл ажиллагааны зардлын дүн буурсан тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 1,870.8 сая төгрөгийг сонгож 29.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын нийт 77.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 35,000.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт		-	-	-	-	-
Албан шаардлага		-	-	-	-	-
Зөвлөмж		3	35,000.0	3	35,000.0	100
Нийт дүн		3	35,000.0	3	35,000.0	100

Өмнөх онд тогтоосон 35,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмжийн биелэлт 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн. Тайлант онд боловсролын, соёл, эрүүл мэндийн салбарын 5 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 223.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитын явцад 60.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 163.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

Залруулсан алдааны талаар:

- Харьяа байгууллагуудын төсвийн тохируулгыг хийж нийт 60.5 сая төгрөгийн залруулга хийсэн.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын зөрчлийн талаар:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 23.8 сая төгрөгийн алдаа залруулж, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 21.7 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 720.3 сая төгрөгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар 1 зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Хөрөнгийн орлого 12.1 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн орлого 1.1 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 0.4 сая төгрөг, байгалийн ургамалын нөөц ашигласны 1.7 сая төгрөг, дуудлага худалдааны орлого 1.0 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.1 сая төгрөг, ААНОАТ-ыг 8.7 сая төгрөг, түрээсийн орлогыг 0.6 сая төгрөг, Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 19.3 сая төгрөг нийт 46.0 сая төгрөгийн 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелүүлээгүй тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 51 иргэнтэй холбоотой 117.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн алдаа	1	60.5			1	60.5	1	60.5				
Дүн	1	60.5			1	60.5	1	60.5				
Харьяа байгууллагуудын алдаа												
Жаргалант сумын ЗДТГ	3	23.8	3	23.8			3	23.8				
Дүн	3	23.8	3	23.8			3	23.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлогын төлөвлөгөө нэр төрлөөр нь тасалсан.	1	46.0					1	46.0				
Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хугацаа хэтэрсэн зээл их.	1	117.0					1	117.0				
Дүн	3	163.0					3	163.0				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	1	720.3			1	720.3						
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй.	1	-					1	-				

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	2.7			1	2.7				
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Хилийн цэсийн самбар, хаалга барьсан	1	21.2		1	21.2					
	4	744.2		2	741.5	2	2.7			

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

ГҮЙЦЭТГЭСЭН:

Л.МӨНХ-ОРГИЛ